

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.25. №62 (62)

ҮЙЛ ЯВДАЛ

“ТЭРГҮҮНИЙ АРДЫН АВЬЯАСТАН ХАМТ ОЛОН”-Ы ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний “Тэргүүний ардын авьяастан хамт олон” шалгаруулах уралдааныг энэ сарын 21-23-ны өдрүүдэд шүүн дүгнэж, шилдгүүдийг тодрууллаа. Хоёр жил тутамд явагддаг уралдааныг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас анх удаа бүрэн хэмжээний

урлагийн тоглолтыг дүрс бичлэгээр бэлтгүүлэн авч, мэргэжлийн шүүгч нар хэлэлцэн дүгнэв. Уралдаанд Зэвсэгт хүчний 16 анги оролцож, удирдамжид заагдсан дуу, хөгжим, бүжиг, ардын язгуур урлаг, уран уншлага, шилдэг үзүүлбэр гэсэн зургаан төрлөөр дүрс бичлэгээр бэлтгэн ирүүлснээс “Тэргүүний ардын авьяастан хамт олон”-ы “Гранпри” өргөмжлөл буюу

шилдгийн шилдэг төрөлд хурандаа Ж.Өсөхбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 167 дугаар анги тэргүүлж, уралдааны нэгдүгээр байрт хурандаа Х.Энхболд захирагчтай Зэвсэгт хүчний 123 дугаар анги, хоёрдугаар байрт хурандаа Ш.Энхбат захирагчтай Зэвсэгт хүчний 353 дугаар анги, гуравдугаарт байрт хурандаа Д.Шинэбаяр захирагчтай

Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн авьяаслаг хамт олон шалгарсан юм. Тэгвэл уралдааны шилдэг төрлүүдэд “Шилдэг гоцлол дуучин”-аар дэд ахлагч Д.Отгонбаяр (326), “Шилдэг гоцлол хөгжимчин”-өөр дэд ахлагч Б.Долгормаа (124), “Шилдэг гоцлол бүжигчин”-ээр ахмад Ө.Энхсаруул (065), “Шилдэг уран уншигч”-аар ахмад Д.Дагвадорж (167), “Язгуур урлагийн шилдэг үзүүлбэр”-ээр “Алтайн магтаал” хамтлаг (120), “Шилдэг үзүүлбэр”-ээр ахлах дэслэгч Ц.Гэрэлтуяа (013), “Найрал дууны шилдэг хамтлаг”-аар Зэвсэгт хүчний 167 дугаар анги, “Хөгжмийн шилдэг хамтлаг”-аар Хулгийн айзам (167), “Бүжгийн шилдэг хамтлаг”-аар Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн бүжгийн хамтлаг тус тус шалгарлаа.

Зэвсэгт хүчний “Тэргүүний ардын авьяастан хамт олон” шалгаруулах урлагийн үзлэг нь Зэвсэгт хүчинд урлаг, соёлыг хөгжүүлэх, тэргүүний ардын авьяастнуудын эгнээг өргөжүүлэх, уран бүтээлчдийн ур чадварыг нэмэгдүүлэх, хамт олны гар нийлэмжтэй ажиллагааг бэхжүүлэх, орон нутгийн соёл урлагийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, бие бүрэлдэхүүний амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрөөх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 11	🌧️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 13

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.443.00	3.502.00
CNY 🇨🇳	441.00	444.40
RUB 🇷🇺	38.10	39.80
JPY 🇯🇵	25.86	26.36
KRW 🇰🇷	2.44	2.58

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 14
2021.05.25.
/МЯГМАР ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ДОЛООН УЛААН
ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:
Эд мал арвидна.
Наран ургах, шингэх:
05.03-20.36
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Хурьцахуй
Суудал:
Шороо.

Аргын тооллын 5 сарын 25, Анргараг гараг. Билгийн тооллын 14, Хонгорцог одтой, харагчин тахиа өдөр. Өдрийн наран 5 цаг 03 минутад мандан, 20 цаг 36 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тулзлалд үйлдхянамагуй хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, гарагийг тахиж хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Улаа гаргах, хиншүү хяравс гаргах, мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

ДИССЕРТАЦИ БИЧИХ АРГА ЗҮЙ СЭДВЭЭР ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯВАГДЛАА



Багшийн хөгжлийн төв эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсаар байна. Өнгөрсөн өдрүүдэд зохион байгуулагдсан “Диссертаци бичих арга зүй” хэлэлцүүлэгт БХЭШХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор П.Цэдэв нар зочин илтгэгчээр оролцож, диссертацийн ажлын сэдэв сонгох, сэдвийн томъёолол, түүнд тавигдах шаардлага, судалгааны зорилго, зорилт, судалгааны объект,

судлах зүйл, судалгааны шинэлэг тал, ач холбогдол зэрэг сэдвийн танилцуулгын бүрдэл хэсгүүдийг хэрхэн оновчтой боловсруулах талаар онол, практикийн мэдээлэл, арга зүйн зөвлөмж оролцогчдод өглөө. Багш, оролцогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн цаг үеэ олсон энэ хэлэлцүүлэгт ҮБХИС-ийн багш нарын төлөөлөл болох 50 багш оролцож диссертацийн ажлыг хэрхэн бичих талаар онолын болон практик мэдээлэл авч, хэлэлцүүлэгт оролцогчид диссертацийн ажлаа бичихэд тулгамдаж буй асуудлуудыг хөндөж ярилцаж, туршлагаа хуваалцлаа.



Өнөөдрийн 08 цагаас 20 цаг хүртэлх цаг агаарын урьдчилсан мэдээ. Өнөөдөр нутгийн төв хэсгээр хур тунадас орж, говь, тал хээрийн нутгаар салхи шуургатай байна.

Ихэнх нутгаар үүлэрхэг. Баруун болон төвийн аймгуудын нутгийн зарим газар, говийн аймгуудын нутгийн хойд хэсэг, зүүн аймгуудын нутгийн баруун хэсгээр бороо, нойтон цас орно. Бусад нутгаар хур тунадас орохгүй. Салхи ихэнх нутгаар баруун хойноос секундэд 6-11 метр, зарим газраар секундэд 14-16 метр хүрч ширүүсэж, шороон шуурга шуурна. Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Завхан голын эх, Туул, Тэрэлж, Онон, Улз, Халх голын хөндийгөөр 8-13 градус, Их нууруудын хотгор болон, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр 18-23 градус, бусад нутгаар 13-18 градус дулаан байна.

УЛААНБААТАР ХОТ ОРЧМООР: Үүлшинэ. Бага зэргийн бороо орно. Салхи баруун хойноос секундэд 6-11 метр, зарим үед секундэд 14-16 метр хүрч ширүүснэ. Өдөртөө 10-12 градус дулаан байна.

БАГАНУУР ОРЧМООР: Үүлшинэ. Хур тунадас орохгүй. Салхи баруун хойноос секундэд 7-12 метр, зарим үед секундэд 14-16 метр хүрч ширүүснэ. Өдөртөө 10-12 градус дулаан байна.

ТЭРЭЛЖ ОРЧМООР: Үүлэрхэг. Бага зэргийн бороо орно. Салхи баруун хойноос секундэд 7-12 метр, зарим үед секундэд 14-16 метр хүрч ширүүснэ. 8-10 градус дулаан байна гэж цаг уур орчны шинжилгээний газраас мэдээллээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 53.100	ЭДГЭРСЭН 46.748	НАС БАРСАН 253/13
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ НИЙТ БАТЛАГДСАН 2421 (34)	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 219	ЭДГЭРСЭН 2166

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 166,346,635
Эдгэрсэн Нийт: 141,873,373
Нас барсан Нийт: 3,449,117

“ЭРҮҮЛ МЭНДИЙНХЭЭ ТӨЛӨӨ - ААХАНГАА ЯРИЦЬЯ”

ДАРХЛААГ ДЭМЖИХ ЦАХИМ АЛЖАЛТЫН 7 ХОНОГ

2021 оны 05 дугаар сарын 24-30 өдөр

ҮЙЛ ЯВДАЛ

ТЭРГҮҮНИЙ РОТ /БАТАРЕЙ/, САЛААНЫ ЗАХИРАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛНО



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын рот (батареи), салааны захирагч нарын зөвлөгөөн 4 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд “Зөв төлөвшил, зөв хүмүүжил” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан билээ. Зөвлөгөөний нэгдүгээр үе шатыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагууд дотооддоо заагдсан хөтөлбөрийн дагуу явуулсан бол хоёрдугаар үе шатыг ЗХЖШ-аас 5 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангаад байна. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас шалгарсан тэргүүний рот (батареи), салааны захирагч

нар нэгдсэн зөвлөгөөнд оролцох бөгөөд онолын болон дадлага, үзүүлэх сургууль, цэргийн албаны баримт бичиг бүрдүүлэлт гэсэн хэлбэрүүдээр Зэвсэгт хүчний хэд хэдэн ангиудын материаллаг баазыг түшиглэн явагдана. Тухайлбал, “Удирдлагын манлайлал”, “Холбоо мэдээллийн дэвшилтэт технологид суурилсан цэргийн сургалт”, “Зөв хандлага, зөв төлөвшил”, “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөлт, зохион байгуулалт”, “Зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлого, хөгжлийн чиг хандлага”, “Буудлагын дасгал боловсруулах аргачлал

үзүүлэх сургууль” зэрэг олон лекц, дадлага, үзүүлэх сургуулиуд багтжээ. Энэ үеэр Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нар тодорхой асуудлуудаар үүрэг, чиглэл өгнө.

Зөвлөгөөн нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн салаа, салбарын офицеруудын биеэр үлгэрлэх, бусдыг чиглүүлэх, үүссэн хүндрэл бэрхшээлийг тодорхойлон түүнийг даван гарах, захирагдагсдаа зоригжуулах, тэднийг нэгтгэн удирдах арга барил, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 327 ДУГААР АНГИЙН ЗАРИМ БҮРЭЛДЭХҮҮН ШАГНАГДАВ

Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд төрийн одон медаль болон салбарын шагналаар зарим бүрэлдэхүүн шагнагдлаа. Тухайлбал, “Цэргийн гавьяаны одон”-гоор ахлах ахлагч Д.Баярхүү, “Цэргийн хүндэт медаль”-аар дэд хурандаа Х.Энхбаатар, хошууч Ц.Номинзул, Д.Даваадорж, ахмад Т.Дамдинсүрэн, сургагч ахлагч Н.Батзориг, Б.Төмөрбаатар, Б.Булган, А.Наранбаатар, ахлах ахлагч М.Ууганбаяр, М.Төмөрбарс нар, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар ажилтан албан хаагч Х.Дэлгэрсайхан, Г.Мөнхтуяа, Ц.Ариунтуяа, А.Алтансүх, С.Доржсүх, “Зэвсэгт хүчин-100 жил” медалиар хурандаа Н.Цэцэнхүү, дэд хурандаа А.Нямбаяр, ахмад Д.Сод-Эрдэнэ, Х.Оюунбат нарын нэр бүхий алба хаагчид шагнагдсан юм. Мөн Батлан



хамгаалах яамны “Жуух бичиг”-ээр ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү шагнагдлаа. Шагналыг нь ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Материал, техникийн төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа С.Баяр-Очир, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Б.Батням нар гардуулан өгч, баяр хүргэсэн юм. Хурандаа С.Баяр-Очир “Түүхт 100 жилийн ойгоор алба хааж

байгаа эрхэм офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид, ажилтан албан хаагчид та бүхэндээ баяр хүргэе. Зэвсэгт хүчин хэмээх их айлын нэгэн гишүүн нь болж, албаны төлөө зүтгэж яваа та бүхнээр бахархаж байна. Цаашдаа өөрсдийгөө хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд анхаарч, ажил албандаа үр бүтээлтэй, санаачилгатай ажиллаарай” гэсэн юм.

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД 300 ГАРУЙ ХАЙЛААС МОД ТАРИЛАА



Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Ангийн хамт олон ангийн түүхт 100 жилийн ойг угтан олон бүтээлч ажил өрнүүлж байгаагийн нэг нь эко, ногоон орчин бүрдүүлэх юм.

Ажлын байрны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эко орчин нөхцөлийг бий болгох зорилгоор хугацаат албаны дайчид ангийн байрлалд 300 гаруй хайлаас мод тарьж, эмэгтэйчүүдийн зөвлөлөөс штаб, шалган нэвтрүүлэх байрны гадна өнгө үзэмжийг сайжруулах хүрээнд цэцгийн мандал байгуулан, арчилгаа, усалгааг тогтмол хийж байна.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

ОРОН НУТАГ РУУ ЗОРЧИГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА



Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул Шарын гол, Дорнод, Дундговь, Орхон, Завхан, Төв Аймаг, Увс, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай аймаг болон нийслэл хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ын дагуу үндэслэн энэ сарын 22-ноос эхлүүлсэн.

“Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-д заасан тээврийн зорчигчдод тавигдах шаардлага, хүлээх үүргийг танилцуулж байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх болон бусад холбогдох баримт

бичгийг биедээ авч явах бөгөөд шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд тухай бүр шалгуулна.

- Нэг удаагийн амны хаалт, бээлий, гар халдваргүйжүүлэгч, хувийн хэрэгцээний эд зүйлс, замд хэрэглэх хоол, хүнс болон хогийн уутыг урьдчилан бэлтгэнэ.

- Зорчигч тээвэрлэлтийн туршид халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдөж, (хооллохоос бусад нөхцөлд нэг удаагийн амны хаалтыг авахгүй байх 2 цаг тутам эсхүл бохирдсон тухай бүр амны хаалтыг солих, гараа бохирдох бүрд халдваргүйжүүлэх, бусадтай биеэр хүрэлцэхгүй байх, ойролцоо суудалд зорчиж буй бусад хүнтэй

харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зай (барих) эрх бүхий ажилтан, албан хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлнэ.

- Зорчигч өөрийн бэлтгэсэн хогийн уутанд хог хаягдлаа хийн битүүмжилж хог хаягдлыг цуглуулах цэгт төвлөрүүлнэ.

- Тээврийн хэрэгсэл дотор болон гадагш нус, цэр, шүлс, хог хаягдлыг ил задгай хаях, утсаар чанга удаан ярихыг хориглоно.

- Халдварын сэжигтэй шинж тэмдэг илэрвэл өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулахаас сэргийлж, энэ талаар тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэгч ажилтанд нэн даруй мэдэгдэнэ гэж УОК-ын Шуурхай штабаас мэдээллээ.

XII АНГИ ТӨГСӨГЧДӨД СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ ЭХЭЛЛЭЭ



“Ковид-19” халдварт цар тахлын үед Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөд шалгалтын өмнөх стресс менежментийг сэтгэл зүйн бэлтгэлд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн сэтгэл зүйчид энэ сарын 24-ний өдрөөс эхлэн фейсбүүкийн чатбоос үйлчилгээг ашиглан зөвлөгөө өгөхөөр боллоо.

Та сэтгэлзүйн зөвлөгөөг мэргэжлийн хүнээс авах бол Боловсролын үнэлгээний төвийн чатботоор холбогдоорой. Мөн 7011-9498 утсанд 10-22 цагийн хооронд хандах боломжтой юм.

МӨНХИЙН БЕСТСЕЛЛЕР

FranklinCovey EDUCATION MONGOLIA Монгол хүн 3030 сан

7 дадлын ГАЙХАМШИГ **Дэлхийг ГЭРЭЛТҮҮЛНЭ**

ЭЦЭГ, ХҮҮ КОВИ НАРЫН БҮТЭЭЛЭЭС

Стефен Р.Кови, Стефен М.Р.Кови, Шонн Кови

Холбоо барих: 89002329, 70140100 info@franklincovey.mn

FranklinCovey Mongolia franklincovey.com, www.theleaderinme.org

СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Эхийг “Соёмбо” сонинны редакцал бэлтгэв.

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эзэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонинны нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонинны мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029